*The number of registration unemployed reached 38.9 thousand at the end of July, 2013, reflecting an decrease of 6.7 thous. person or 14.7 percent compared to same period of the previous year.*

*In the first 7 months of 2013, 673.6 thous.persons were registered as insurer, of which 449.5 thousand or 66.7 percent were those from the establishments, and 224.1 thousand or 33.3 percent from the government budgetary organization. Compared to same period of the previous year, the number of insurers increased by 60.2 thousand or 9.8 percent, of which the increased by 44.9 thousand or 11.1 percent from establishments, and increased by 15.3 thousand or 7.3 percent from government budgetary organization.*

*In the first 7 months of 2013, social welfare pensions and benefits allocated to 61.9 thous.persons, 5.3 thous.persons or 9.3 percent, total amount of the allocated fund increased by 9.9 bln.tog or 31.5 percent compared to same period of the previous year.*

*In the first 7 months of 2013, a total of 130.5 bln.tog distributed for 926.7 thousand children ages below 18 by the Human Development Fund for children. For the 21 thous.tog cash allowances to allocated from The Human Development fund paid 154.4 thous.persons a total 18.5 bln.tog. For the one mln.tog cash allowances to allocated from The Human Development fund for*

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2013 оны эхний 7 сард 24530 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2533 хүн буюу 9.4 хувиар буурахад салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 1764 хүн буюу 97.5 хувь, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 993 хүн буюу 38.7 хувиар өссөн хэдий ч гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 2568 буюу 34.1 хувь, вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 2496 буюу 2.4 дахин буурснаас голлон шалтгаалжээ.

Улсын хэмжээнд 2013 оны эхний 7 сард 14816 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2004 хэрэг буюу 15.6 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (1353), хүний амь бие эрүүл мэндийн эсрэг (685) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2013 оны эхний 7 сард 5198 хүн гэмтэж, 614 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 257 буюу 5.2 хувь, нас барсан хүний тоо 1 буюу 0.2 хувиар нэмэгдсэн байна.

## II.Макро эдийн засгийн үзүүлэлт

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2013 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 7591.0 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2702.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс оны үнээр 18.8 хувь, зэрэгцүүлэх үнээр 11.3 хувиар өслөө.

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2013 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 0.1 хувь, оны эхнээс 4.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.3 хувиар өслөө.

Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 1.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2013 оны 7 дугаар сарын эцэст 8095.7 тэрбум

elderly and disabled of 4.9 thous.persons, the fund paid a total 4.7 bln.tog.

In the first 7 months of 2013, the number of infectious disease cases was 24530 persons, decrease by 2533 cases or 9.4 percent compared to same period of the previous year. The decrease in the number of infectious disease cases was mainly due to the increases of 1764 persons or 97.5 percent in varicella, 993 persons or 38.7 percent in syphilis although there were decreases of 2568 persons or 34.1 percent in mumps, 2496 or 2.4 times in viral hepatitis.

At national level, 14816 crimes were registered in the first 7 months of 2013, reflecting an increase of 2004 crimes or 15.6 percent compared to same period of the previous year. The increase in the number of crimes was mainly due to the increases in crime against the right of ownership (1353), crime against human life and health (or physical well-being) (685), compared to same period of the previous year.

In the first 7 months of 2013, occurred crimes caused 5198 injuries and 614 deaths. The number of injuries up by 257 persons or 5.2 percent and the number of deaths 1 person or 0.2 percent compared to same period of the previous year.

## II.Macroeconomic indicators

GDP by production approach reached 7591.0 bln.tog at current price, 2702. 1 bln. tog at 2005 constant price in the first half of 2013, up by 18.8 percent at current price and 11.3 percent at constant price compared to the same period of the previous year.

The national consumer price index in July, 2013, increased by 0.1 percent compared to the previous month, 4.9 percent compared to the beginning of the year, and 8.3 percent compared to same period of the previous year.

The increase in national index compared to the previous month was mainly due to 0.5 percent increase in Clothing, footwear & cloth 1.8 percent in housing, water, electricity & fuels.

According to the report of the Bank of Mongolia, money supply (broad money

төг болж, өмнөх сарынхаас 91.7 тэрбум төг буюу 1.1 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 1142.2 тэрбум төг буюу 16.4 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2013 оны 7 дугаар сарын эцэст 832.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 3.6 тэрбум төг буюу 0.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 30.8 тэрбум төг буюу 3.8 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2013 оны 7 дугаар сарын эцэст 9117.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 509.5 тэрбум төг буюу 5.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2688.7 тэрбум төг буюу 41.8 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2013 оны 7 дугаар сарын эцэст 161.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 11.6 тэрбум төг буюу 7.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 76.2 тэрбум төг буюу 89.5 хувиар өсчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2013 оны 7 дугаар сарын эцэст 452.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 136.1 тэрбум төг буюу 43.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 147.0 тэрбум төг буюу 48.1 хувиар өссөн байна.

Үнэт цаасны арилжаагаар 2013 оны эхний 7 сард 13.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 23.3 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс үнэт цаасны гүйлгээ 48.1 тэрбум төг буюу 77.6 хувь, арилжигдсан үнэт цаасны тоо 87.2 сая ш буюу 79.0 хувиар буурчээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн нийт хэмжээ 2013 оны эхний 7 сард 3040.0 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3185.7 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 145.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Нэгдсэн төсвийн урсгал орлого 3039.5 тэрбум төг, урсгал зардал 2531.3 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 508.2 тэрбум төгрөгийн ашигтай

or M2) at the end of July 2013, reached to 8095.7 bln.tog, increased of 91.7 bln.tog or 1.1 percent compared to the previous month, and increased by 1142.2 bln.tog or 16.4 percent compared to same period of the previous year.

At the end of July 2013, currency issued in circulation reached 832.2 bln.tog, decreased by 3.6 bln.tog or 0.4 percent compared to the previous month, and increased by 30.8 bln.tog or 3.8 percent compared to same period of the previous year.

Loans outstanding at the end of July 2013, amounted to 9117.2 bln.tog, up by 509.5 bln.tog or 5.9 percent compared to the previous month, and up by 2688.7 bln.tog or 41.8 percent compared to same period of the previous year.

Principals in arrears at the end of July 2013, reached 161.3 bln.tog, increased by 11.6 bln.tog or 7.7 percent compared to the previous month, increased by 76.2 bln.tog or 89.5 percent compared to same period of the previous year.

At the end of July, 2013, the non-performing loans over the bank system reached 452.7 bln.tog, showing increases of 136.1 bln.tog or 43.0 percent compared to the previous month, 147.0 bln.tog or 48.1 percent compared to same period of the previous year.

In Securities trading of the first 7 months of 2013, the 23.3 mln.shares valued at 13.9 bln.tog were traded. The Securities trading was decreased by 48.1 bln.tog or 77.6 percent and shares decreased by 87.2 mln or 79.0 percent compared to same period of the previous year.

In the first 7 months of 2013, total equilibrated revenue and grants of the General Government Budget amounted to 3040.0 bln.tog and total expenditure and net lending amounted to 3185.7 bln.tog, representing deficit of 145.6 bln.tog in the equilibrated balance of General Government Budget.

Current revenue of the General Government Budget amounted to 3039.5 bln.tog and current expenditure reached 2531.3 bln.tog. Thus, the budget equilibrated current

гарлаа.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 184.2 тэрбум төг буюу 7.5 хувиар нэмэгдэхэд бусад татвар 175.6 тэрбум төг буюу 34.5 хувиар буурсан хэдий ч дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 148.2 тэрбум төг буюу 16.8 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 102.4 тэрбум төг буюу 28.2 хувь, орлогын албан татварын орлого 100.7 тэрбум төг буюу 20.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 119.8 тэрбум төг буюу 41.8 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 17.7 тэрбум төг буюу 71.4 хувь, бусад нэр заагдаагүй орлого 9.2 тэрбум төг буюу 23.1 хувиар буурсан хэдий ч хүү, торгуулийн орлого 60.8 тэрбум төг буюу 2.8 дахин, газрын тосны орлого 45.2 тэрбум төг буюу 2.2 дахин, төсөвт газрын өөрийн орлого 37.2 тэрбум төг буюу 30.1 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2013 оны эхний 7 сард 3185.7 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 158.5 тэрбум төг буюу 4.7 хувиар буурсан нь эргэж төлөгдөх цэвэр зээл 33.4 тэрбум төг буюу 94.3 хувь, бараа, үйлчилгээний зардал 162.1 тэрбум төг буюу 14.3 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 73.1 тэрбум төг буюу 2.4 дахин өссөн хэдий ч хөрөнгийн зардал 136.4 тэрбум төг буюу 18.9 хувь, татаас ба шилжүүлгийн зардал 290.8 тэрбум төг буюу 20.7 хувиар буурснаас шалтгаалжээ.

Монгол Улс 2013 оны эхний 7 сард дэлхийн 122 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 6038.7 сая ам.долл, үүнээс экспорт 2353.6 сая ам.долл, импорт 3685.0 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2013 оны эхний 7 сард 1.3 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 98.4 сая ам.долл буюу 6.9 хувиар буурчээ.

Гадаад худалдааны Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 467.5 сая ам.долл буюу 7.2 хувь, үүний дотор импортын хэмжээ 283.0 сая ам.долл

*balance was in surplus of 508.2 bln.tog.*

*Compared to same period of the previous year, non-tax revenue increased by 184.2 bln.tog or 7.5 percent. The increase was mainly due to the increases of 148.2 bln.tog or 16.8 percent in taxes on goods & services, 102.4 bln.tog or 28.2 percent in social security contribution, 100.7 bln.tog or 20.5 percent in income tax although there was decreases of 175.6 bln.tog or 34.5 percent in other taxes.*

*Compared to same period of the previous year, non-tax revenue increased by 119.8 bln.tog or 41.8 percent. The increase was mainly due to the increases of 60.8 bln.tog or 2.8 times in interest and fines, 45.2 bln.tog or 2.2 times in revenues from oil petroleum, 37.2 bln.tog or 30.1 percent in revenues from budget entities although there was decreases of 17.7 bln.tog or 71.4 percent in revenues from dividends, 9.2 bln.tog or 23.1 percent in revenues from others .*

*In the first 7 months of 2013, total expenditure and net lending of the General Government Budget decreased by 158.5 bln.tog or 4.7 percent to 3185.7 bln.tog compared to same period of the previous year. This was mainly due to increases of 33.4 bln.tog or 94.3 percent in lending minus repayments, 162.1 bln.tog or 14.3 percent in expenditure of goods and services, 73.1 bln.tog or 2.4 times in interest payments, although there was decreases of 136.4 bln.tog or 18.9 percent in capital expenditure, 290.8 bln.tog or 20.7 percent in subsidies and transfers.*

*In the first 7 months of 2013, Mongolia traded with 122 countries from all over the world and total external trade turnover reached 6038.7 mln.US dollars, of which exports made up 2353.6 mln.US dollars and imports made up 3685.0 mln.US dollars.*

*Foreign trade balance showed a deficit of 1.3 bln.US dollars in the first 7 months of 2013, reflecting 98.4 mln.US dollars or 6.9 percent decrease compared to same period of the previous year.*

*Total external trade turnover decreased by 467.5 mln.US dollars or 7.2 percent, of which imports down by 283.0 mln.US dollars or 7.1 percent, and exports down by 184.5*

буюу 7.1 хувь, экспортын хэмжээ 184.5 сая ам.долл буюу 7.3 хувиар буурчээ.

Экспортын 97.6 хувийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна.

*mln.US dollars or 7.3 percent, compared to same period of the previous year.*

*Mineral products, textile articles, natural or cultured stones, precious metal, jewelry, coins, raw & processed hides, skins, fur & articles, animal origin products, auto & air water transport vehicles & their spare parts accounted for 97.6 percent of the total export value amount.*

### III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

### III. Economic sector indicators

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2013 оны эхний 7 сард 1318.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 104.6 тэрбум төг буюу 8.6 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын цайрын баяжмал, зэсийн баяжмал, газрын тос, алт зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.2-73.9 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ном, амтат ус ундаа, шингэн сүү, хиаман төрлийн бүтээгдэхүүн, металл цувимал, ган төмөр хийц, нарийн боов, гурил, самнасан ноолуур, барилгын модон хаалга, цонх, бетон зуурмаг, вакуум цонх, хаалга, савласан ногоон цай, хэвлэмэл хуванцар картууд зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.4 хувиас 5.2 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Төмөр замын тээврээр 2013 оны эхний 7 сард 11841.0 мян.т ачаа тээж, давхардсан тоогоор 2247.2 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 253.0 мян.т буюу 2.2 хувиар өсч, зорчигчдын тоо 101.5 мян.хүн буюу 4.3 хувиар буурчээ. Төмөр замын тээврийн салбарын орлого 2013 оны эхний 7 сард 241.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.0 тэрбум төг буюу 1.2 хувиар буурчээ.

Агаарын тээврээр 2013 оны эхний 7 сард 2332.9 т ачаа тээж, давхардсан тоогоор 439.1 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 69.6 т буюу 3.1 хувь, зорчигчдын тоо 35.7 мян.хүн буюу 8.8 хувиар өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр агаарын тээврийн салбарын орлого 2013 оны эхний

*In the first 7 months of 2013, the total industrial output increased by 104.6 bln.tog or 8.6 percent to 1318.0 bln.tog (at 2005 constant prices) compared to same period of the previous year. The increase in the industrial output was mainly due to 0.2-73.9 percent, increases in mining and quarrying products such as zincum concentrate, 35 percent, crude oil, gold and 0.4 percent to 5.2 times increases in industrial main products of manufacturing sector such as book, soft drinks, milk, kind of sausage, metal foundries, steel casting, bakery products, flour, combed down, wooden building door and windows, concrete mortar, vacuum windows and doors, green tea, printing plastic card.*

*In the first 7 months of 2013, 11841.0 thous.t freight and 2247.2 thous.passengers (double counting) were carried by railway transport. Compared to same period of the previous year, the number of carried freight increased by 253.0 thous.t or 2.2 percent and the number of carried passengers decreased by 101.5 thous.persons or 4.3 percent. The revenue from railway transport decreased by 3.0 bln.tog or 1.2 percent to 241.0 bln.tog in the first 7 months of 2013, compared to same period of the previous year.*

*In the first 7 months of 2013, 2332.9 t freight and 439.1 thous.passengers (double counting) were carried by air transport. Compared to same period of the previous year, the number of carried freight increased by 69.6 t or 3.1 percent, the number of carried passengers increased by 35.7 thous.persons or 8.8 percent. Due to the increase in carried freight and passengers, revenue from air*

7 сард 125.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 14.3 тэрбум төг буюу 12.9 хувиар өслөө.

*transport increased by 14.3 bln.tog or 12.9 percent to 125.4 bln.tog in the first 7 months of 2013, compared to same period of the previous year.*

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2013 оны 7 дугаар сард Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд орж 138.5 мм-т хүрчээ. Энэ оны 7 дугаар сард Дорноговь аймгийн Хөвсгөл суманд хамгийн их температур 40.0 хэм, Баян-Өлгий аймгийн Алтай, Завхан аймгийн Цэцэн-Уул, Баянхонгор аймгийн Жаргалант, Архангай аймгийн Тариат сум, Налайх дүүргийн Тэрэлж тосгонд хамгийн бага температур 1.0 хэм байлаа. Салхины хамгийн их хурд Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 28 м/с хүрчээ.

*According to the report of the Institute of Meteorology and Hydrology, maximum precipitation was registered in Arvaikheer soum (138.5 mm) of Ovorkhangai aimag in July 2013. In July 2013, Khovsgol soum of Dornogobi aimag had the highest air temperature (40.0°C), while Altai soum of Bayan-Olgii aimag and Tsetsen-Uul soum of Zavkhan aimag and Jargalant soum of Bayankhongor aimag and Tariat soum of Arkhangai aimag and Nalaih district Terelj village had the lowest air temperature (1.0°C). Wind speed reached 28 m/sec in Olgii soum of Bayan-Olgii aimag.*

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2013 оны 7 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 30 удаа, Баруун дөрвөн замын орчимд 21 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 15 удаа, Хархорин захын орчимд 13 удаа, 13-р хороолол орчимд 6 удаа, 32-ын тойрог орчимд 3 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 13-р хороололд орчимд 3 удаа, Баруун дөрвөн замын орчимд 2 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс тус тус давсан байна.

*Daily average concentration of nitrogen dioxide exceeded 30 times around the 13th micro district of Ulaanbaatar city, 21 times around the West crossroad, particulate matter less than 10 micrograms exceeded 15 times around the West crossroad, 13 times around Kharkhorin market, 6 times around the 13th micro district, 3 times around the 32nd Toirog, particulate matter less than 2.5 micrograms exceeded 3 times around the 13th micro district, 2 times around the West crossroad from the maximum allowable concentration of air quality standard in July 2013.*

Аюулт үзэгдэл, осол 2013 оны эхний 7 сард 2896 удаа гарсны улмаас 117 хүн амь насаа алдаж, 234.9 мянган толгой мал, тэжээвэр амьтан хорогджээ. Энэ оны эхний 7 сард объектын түймэр 2484 удаа, ой, хээрийн түймэр 128 удаа, гол, нуурын усанд хүн унасан осол 56 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 46 удаа, хүчтэй салхи, шуурга 34 удаа, аадар бороо, үерийн аюулт үзэгдэл 29 удаа, 3.5-аас дээш магнитудын газар хөдлөлт 28 удаа, үйлдвэрийн осол 22 удаа, химийн хорт бодисын алдагдалтай холбоотой ослын дуудлага, аянгын аюулт үзэгдэл тус бүр 14 удаа, хүн, малын халдварт боом өвчин, үхрийн хорт салст халуурал өвчин, сум галт хэрэгслийн осол тус бүр 8 удаа, бичил уурхайн нурангины осол 7 удаа, тэсэрч дэлбэрэх бодисын осол 3

*In the first 7 months of 2013, 2896 disasters and accidents occurred. As a result, 117 people died, 234.9 thous.livestock and animals had lost. There were 2484 times fires of constuction, 128 times fires on forest, 56 times floods and river and lake accidents, 46 times animal madness diseases, 34 times severe storms, 29 times heavy rain and floods, 3.5 magnitude earthquake 28 times, industrial accident 22 times, 14 incidents related to chemical substance usage and emergency calls and thunder, 8 times anthrax, malignant catarrhal fever and slug firearms accidents, 7 times artisanal mining and rock falls, 3 times chemical substance usage and emergency calls, 2 times hailstorm, 1times disaster, glaze and maedi and visna, aphthous fever, animal infections, food poisoning in the first 7 months of 2013. In the first 7 months of 2013, estimated damage caused by the*

удаа, мөндөрийн аюулт үзэгдэл 2 удаа, зуд болон малын халдварт маеди весна өвчин, шүлхий, малын гоц халдварт цэцэг өвчин, хоолны хордлого тус бүр 1 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас энэ оны эхний 7 сард объектын түймэрт 6.8 тэрбум төг, ой, хээрийн түймэрт 3.2 тэрбум төг, хүчтэй салхи шуурганы аюулт үзэгдэлд 618.1 сая төг, аадар бороо, үерийн аюулт үзэгдэлд 189.4 сая төг, аяндын аюулт үзэгдэлд 82.8 сая төг, мал, амьтны халдварт галзуу өвчинд 13.6 сая төг, хүн, малын халдварт боом, үхрийн хорт салт халуурал өвчин, тэсэрч дэлбэрэх бодисын осол, үйлдвэрлэлийн ослоор нийтдээ 9.1 сая төгрөгийн хохирол иргэн болон байгууллагад учирсан байна.

Гол нуурын усанд унасан ослоор 54 хүн, объектын түймрээр 40 хүн, үйлдвэрлэлийн ослоор 10 хүн, бичил уурхайн нурангины ослоор 6 хүн, аяндын аюулт үзэгдлээр 3 хүн, ой, хээрийн түймэрт 2 хүн, аадар бороо үерийн аюулт үзэгдэл, хүчтэй салхи шуурганы улмаас тус бүр 1 хүн амь насаа алджээ.

Өмнөх оны мөн үеийнхээс аюулт үзэгдэл, ослын тохиолдол 323-аар нэмэгдэв.

Хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтдын тоо 2013 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеийнхээс 227.0 мян.толгойгоор их байна.

*disasters and accidents amounted to fires of construction 6.8 bln.tog, fires on forest 3.2 bln.tog, severe storms 618.1 mln.tog, heavy rain and floods 189.4 mln.tog, thunder 82.8 mln.tog, animal madness diseases 13.6 mln.tog, anthrax, malignant catarrhal fever and slug firearms accidents and industrial accident 9.1 mln.tog.*

*In the first 7 months of 2013, floods and river and lake accidents 54 people, fires of construction 40 people, industrial accident 10 people, artisanal mining and rock falls 10 people, artisanal mining and rock falls 6 people, fires on forest 2 people, floods and pour and severe storm and industrial accident 1 people died.*

*Compared to same period of previous year, disaster and accidents occurred up by 323.*

*A loss and deaths of livestock and animals increased by 227.0 thous.heads in the first 7 months of 2013 compared of the previous year.*

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА



С.МЭНДСАЙХАН

CHAIRMAN OF THE NATIONAL STATISTICAL  
OFFICE OF MONGOLIA

S.MENDSAIKHAN

2013 оны 8 дугаар сарын 10  
10 August, 2013



**ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар**  
**MAIN INDICATORS, as of the first 7 months of selected years**

Үзүүлэлтүүд	Indicators	2012 I-VII	2013 I-VII	2013 I-VII 2012 I-VII	%
<b>Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд</b>	<b>Social statistical indicators</b>				
Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)	Number births (live births)	42 759	46 043		107.7
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, 7 дугаар сарын эцэст	Unemployment, end of the July,	45637.0	38924.0		85.3
Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо	Number of infectious disease cases	27 063	24 530		90.6
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	Number of committed offences	12 812	14 816		115.6
<b>Макро эдийн засгийн статистикийн</b>	<b>Macro economic statistical indicators</b>				
ДНБ,оны үнээр, тэрбум төг	GDP at current price, bln.tog	6 391.6	7591.0**		118.8
ДНБ, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	GDP at 2005 constant prices, bln.tog	2427.5	2702.1**		111.3
Хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, оны эхнээс, хувиар	National consumer price index, from the beginning of the year, percent	10.4	4.9		-
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө*, 7 дугаар сарын эцэст, тэрбум төг	Currency in circulation * end of the July, bln.tog	801.4	832.2**		118.9
Мөнгө M1* 7 дугаар сарын эцэст, тэрбум төг	Money M1* end of the July, bln.tog	1 660.4	1927.6**		106.5
Мөнгө M2* 7 дугаар сарын эцэст, тэрбум төг	Money M2* end of the July, bln.tog	6 953.5	8095.7**		117.5
Валютын зах зээлийн нэрлэсэн ханш, 7 дугаар сарын дундаж, 1 ам.доллар=төгрөг*	Market exchange rate, average of the July  1 USD=togrog*	1 344.0	1 474.0		109.7
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ тэрбум төг	Total equilibrated revenue and grants of General Government, bln.tog	2 744.5	3 040.0		110.8
Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээл, тэрбум төг	Total expenditure and Net lending of General Government, bln.tog	3 344.1	3 185.7		95.3
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл, тэрбум төг	General Government budget overall equilibrated balance, bln.tog	- 599.4	145.6		-
Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого, тэрбум төг	General Government current budget revenue, at current price, bln.tog	2 735.3	3 039.5		111.1
Улсын нэгдсэн төсвийн урсгал зарлага, тэрбум төг	General Government current budget expenditure, at current price, bln.tog	2 586.8	2 531.3		97.9
Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл, тэрбум төг	General Government budget equilibrated current balance, bln.tog	148.7	508.2		341.8
Экспорт, сая ам.долл	Exports, mln.USD	2 538.2	2 353.6		92.7
Импорт, сая ам.долл	Imports, mln.USD	3 968.0	3 685.0		92.9
Гадаад худалдааны тэнцэл, сая ам.долл	External trade balance, mln.USD	-1 429.8	-1 331.4		93.1
<b>Эдийн засгийн статистикийн үзүүлэлт</b>	<b>Economic statistical indicators</b>				
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	Gross industrial output, at 2005 constant prices, bln.tog	1 213.4	1 318.0		108.6
Үүнээс:	Of which:				
-Уул уурхай, олборлох үйлдвэр	-Mining and quarrying	696.8	775.4		111.3
-Боловсруулах аж үйлдвэр	-Manufacturing	382.1	399.7		104.6
-Цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж	-Electricity, thermal energy and water supply	134.4	142.9		106.3
Төмөр замын тээврээр тээсэн ачаа мян.т	Carried freight by railway transport, thous.t	11 588.0	11 841.0		102.2
Төмөр замын тээврээр зорчсон зорчигчдын тоо, мян.хүн	Carried passengers by railway transport, thous.persons	2 348.7	2 247.2		95.7
Агаарын тээврээр тээсэн ачаа,т	Carried freight by air transport, thous.t	2 263.3	2 332.9		103.1
Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо, мян.хүн	Carried passengers by air transport, thous.persons	403.4	439.1		108.8

\*Тайлбар:-Урьдчилсан гүйцэтгэлээр

\*Note: Preliminary estimates

\*\*Эхний хагас жилийн байдлаар

\*\* First half of selected years

**I. ХӨДӨЛМӨР**  
**LABOUR**

1.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО, дэд салбараар, жил бүрийн 7дугаар сарын эцсийн байдлаар  
EMPLOYMENT IN INDUSTRY, by subdivisions, at the end of July of the selected years

Аж үйлдвэрийн салбар	Industrial division	2012 VII	2013 VII	2013 VII 2012 VII %
<b>Аж үйлдвэрийн салбар</b>	<b>Industrial division</b>	<b>57 689</b>	<b>65 143</b>	<b>112.9</b>
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>	<b>Mining and quarrying</b>	<b>18 813</b>	<b>23 351</b>	<b>124.1</b>
Нүүрс олборлолт	Mining of coal and lignite, extraction of peat	6 620	7 743	117.0
Газрын тос олборлолт	Extraction of crude petroleum	996	1 786	179.3
Металлын хүдэр олборлолт	Mining of metal ores	9 329	11 755	126.0
Бусад ашигт малтмал олборлолт	Other mining and quarrying	1 868	2 067	110.7
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>Manufacturing</b>	<b>26 050</b>	<b>28 778</b>	<b>110.5</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	Manufacture of food products and beverages	9 858	11 105	112.6
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	Production, processing and preserving of meat, fish, fruit, vegetables, oils, fats	1 099	1 404	127.8
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of dairy products	769	880	114.4
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	Manufacture of grain mill products, starches, starch products, and prepared animal feeds	638	1 114	174.6
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of other food products	3 746	3 749	100.1
Ундаа үйлдвэрлэл / согтууруулах ундаа ороод /	Manufacture of beverages / includes alcohol drinks/	3 606	3 958	109.8
Тамхи үйлдвэрлэл	Manufacture of tobacco products	155	119	76.8
Нэхмэлийн үйлдвэрлэл	Manufacture of textiles	4 599	4 436	96.5
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	Manufacture of wearing apparel, dressing and dyeing of fur	1 139	1 277	112.1
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	Tanning, dressing of leather, manufacture of luggage, handbags, saddlery harness, footwear	517	733	141.8
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	Manufacture of wood and wooden products	1 141	1 051	92.1
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of paper and paper products	342	351	102.6
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	Publishing, printing and reproduction of recorded media	1 006	1 031	102.5
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	Manufacture of coke and briquette	166	232	139.8
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of chemicals and chemical products	1 274	1 085	85.2
Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of rubber and plastics products	163	230	141.1
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	Production of other non-metallic mineral products	3 127	4 565	146.0
Төмрийн үйлдвэрлэл	Manufacture of basic metals	1 605	1 546	96.3
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	Manufacture of fabricated metal products, except machinery	484	546	112.8
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	Manufacture of office accounting and computing	43	55	127.9
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of electrical and apparatus	51	17	33.3
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of medical precision and optical instruments	61	57	93.4
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of other transport equipment	120	135	112.5
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	Manufacture of furniture others	199	207	104.0
<b>Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж</b>	<b>Electricity, thermal energy and water supply</b>	<b>12 826</b>	<b>13 014</b>	<b>101.5</b>
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	Electricity, thermal energy, steam	9 380	9 576	102.1
Ус ариутгал, усан хангамж	Collection, purification and distribution of water	3 446	3 438	99.8

1.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ\*, дэд салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

LABOUR PRODUCTIVITY OF INDUSTRIAL SECTOR \*, by subdivisions, at 2005 constant prices, as first 7 months of selected years

Аж үйлдвэрийн салбар	Industrial division	мян.мөг thous.tog		
		2012 I-VII	2013 I-VII	2013 I-VII 2012 I-VII %
<b>Аж үйлдвэрийн салбар</b>	<b>Industrial division</b>	<b>21 692.2</b>	<b>21 766.7</b>	<b>100.3</b>
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>	<b>Mining and quarrying</b>	<b>39 493.2</b>	<b>39 020.4</b>	<b>98.8</b>
Нүүрс олборлолт	Mining of coal and lignite, extraction of peat	22 545.2	17 175.1	76.2
Газрын тос олборлолт	Extraction of crude petroleum	148 080.0	123 024.4	83.1
Металлын хүдэр олборлолт	Mining of metal ores	50 516.0	54 250.7	107.4
Бусад ашигт малтмал олборлолт	Other mining and quarrying	7 160.1	3 429.9	47.9
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>Manufacturing</b>	<b>15 632.3</b>	<b>14 979.0</b>	<b>95.8</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	Manufacture of food products and beverages	18 491.0	17 097.4	92.5
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	Production, processing and preserving of meat, fish, fruit, vegetables, oils, fats	5 229.8	4 259.1	81.4
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of dairy products	20 719.5	15 895.8	76.7
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	Manufacture of grain mill products, starches, starch products, and prepared animal feeds	23 380.4	20 375.8	87.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of other food products	5 075.7	5 829.2	114.8
Ундаа үйлдвэрлэл / согтууруулах ундаа ороод /	Manufacture of beverages / includes alcohol drinks/	35 386.2	32 301.0	91.3
Тамхи үйлдвэрлэл	Manufacture of tobacco products	75 185.5	71 105.3	94.6
Нэхмэлийн үйлдвэрлэл	Manufacture of textiles	9 904.6	10 172.3	102.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	Manufacture of wearing apparel, dressing and dyeing of fur	2 615.0	2 739.6	104.8
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	Tanning, dressing of leather, manufacture of luggage, handbags, saddlery harness, footwear	7 277.8	9 682.3	133.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	Manufacture of wood and wooden products	1 522.6	1 401.9	92.1
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of paper and paper products	7 151.4	5 110.6	71.5
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	Publishing, printing and reproduction of recorded media	7 597.7	9 873.3	130.0
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	Manufacture of coke and briquette	196 739.5	230 933.4	117.4
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of chemicals and chemical products	10 596.2	13 833.9	130.6
Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of rubber and plastics products	40 596.7	26 995.5	66.5
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	Production of other non-metallic mineral products	13 764.7	7 721.0	56.1
Төмрийн үйлдвэрлэл	Manufacture of basic metals	24 745.3	24 683.5	99.8
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	Manufacture of fabricated metal products, except machinery	176.6	245.6	139.1
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	Manufacture of office accounting and computing	78 121.0	23 325.7	29.9
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of electrical apparatus	59 401.0	11 397.8	19.2
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of medical precision and optical instruments	51.5	71.3	138.4
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of other transport equipment	2 214.7	1 782.5	80.5
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	Manufacture of furniture others	11 326.7	2 266.7	20.0
<b>Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж</b>	<b>Electricity, thermal energy and water supply</b>	<b>9 705.7</b>	<b>10 208.3</b>	<b>105.2</b>
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	Electricity, thermal energy, steam	12 132.2	12 773.6	105.3
Ус ариутгал, усан хангамж	Collection, purification and distribution of water	2 339.2	2 373.2	101.5

Тайлбар:

\* Нэг ажиллагчид ногдох нийт үйлдвэрлэл (Ажиллагчдын тоо эхний 7 сарын дунджаар).

Note:

\* Gross output per employees (Number of employees as of average first 7 months).

1.3 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО\*, бүс, аймаг нийслэлээр, жил бүрийн 7 дугаар сарын эцэст  
 NUMBER OF REGISTERED UNEMPLOYED\*, by regions, aimags and the Capital, at the end of July of selected years

Аймаг, нийслэл Aimags and the Capital	2012 VII	Эмэгтэй Female	2013 VII	Эмэгтэй Female	2013 VII 2012 VII %
<b>Дүн / Total</b>	<b>45 637</b>	<b>23 147</b>	<b>38 924</b>	<b>20 708</b>	<b>85.3</b>
<b>Баруун бүс/ Western region</b>	<b>6 357</b>	<b>3 233</b>	<b>5 512</b>	<b>3 013</b>	<b>86.7</b>
БӨ / BO	1 014	386	1 125	535	110.9
ГО / GO	879	512	935	571	106.4
ЗА / ZA	1 280	686	930	476	72.7
УВ / UV	695	368	857	479	123.3
ХО / KHO	2 489	1 281	1 665	952	66.9
<b>Хангайн бүс/ Khangai region</b>	<b>11 412</b>	<b>5 689</b>	<b>10 107</b>	<b>5 355</b>	<b>88.6</b>
АР / AR	1 621	798	1 562	775	96.4
БХ / BKH	1 845	981	1 433	820	77.7
БУ / BU	629	344	723	401	114.9
ОР / OR	1 822	923	1 958	1 085	107.5
ӨВ / OV	2 747	1 385	2 588	1 335	94.2
ХӨ / KHS	2 748	1 258	1 843	939	67.1
<b>Төвийн бүс/ Central region</b>	<b>6 305</b>	<b>3 030</b>	<b>6 356</b>	<b>3 560</b>	<b>100.8</b>
ГС / GS	150	85	125	77	83.3
ДА / DA	1 961	959	2 240	1 215	114.2
ДО / DO	743	270	999	558	134.5
ДУ / DU	462	244	550	337	119.0
ӨМ / OM	369	106	723	415	195.9
СЭ / SE	1 334	698	1 153	640	86.4
ТӨ / TO	1 286	668	566	318	44.0
<b>Зүүн бүс/ Eastern region</b>	<b>3 852</b>	<b>1 996</b>	<b>5 459</b>	<b>2 690</b>	<b>141.7</b>
ДД / DD	1 849	771	3 490	1 723	188.8
СҮ / SU	893	525	909	417	101.8
ХЭ / KHE	1 110	700	1 060	550	95.5
<b>Улаанбаатар/ Ulaanbaatar</b>	<b>17 711</b>	<b>9 199</b>	<b>11 490</b>	<b>6 090</b>	<b>64.9</b>
УБ / UB	17 711	9 199	11 490	6 090	64.9

\* Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

\* Monthly report of the Ministry of Labour

1.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО\*, насны бүлгээр, 2013 оны 7 дугаар сарын эцэст  
 NUMBER OF REGISTERED UNEMPLOYED\*, by age groups, at the end of July, 2013

Аймаг, нийслэл Aimags and the Capital	Бүгд		Үүнээс: Насны бүлгээр Of which: By age groups							
	Total	Эмэгтэй Female	15-24	Эмэгтэй Female	25-34	Эмэгтэй Female	35-44	Эмэгтэй Female	45-59	Эмэгтэй Female
<b>Дүн / Total</b>	<b>38 924</b>	<b>20 708</b>	<b>10 256</b>	<b>5 428</b>	<b>13 543</b>	<b>7 455</b>	<b>8 531</b>	<b>4 690</b>	<b>6 594</b>	<b>3 135</b>
<b>Баруун бүс/ Western region</b>	<b>5 512</b>	<b>3 013</b>	<b>1 513</b>	<b>850</b>	<b>1 793</b>	<b>977</b>	<b>1 304</b>	<b>752</b>	<b>902</b>	<b>434</b>
БӨ / BO	1 125	535	338	164	395	189	248	126	144	56
ГО / GO	935	571	234	141	311	183	205	143	185	104
ЗА / ZA	930	476	204	113	313	152	268	140	145	71
УВ / UV	857	479	186	115	272	156	229	132	170	76
ХО / KHO	1 665	952	551	317	502	297	354	211	258	127
<b>Хангайн бүс/ Khangai region</b>	<b>10 107</b>	<b>5 355</b>	<b>2 636</b>	<b>1 305</b>	<b>3 555</b>	<b>2 023</b>	<b>2 326</b>	<b>1 290</b>	<b>1 590</b>	<b>737</b>
АР / AR	1 562	775	340	140	697	382	365	178	160	75
БХ / BKH	1 433	820	389	221	464	276	348	208	232	115
БУ / BU	723	401	162	72	216	121	187	121	158	87
ОР / OR	1 958	1 085	629	322	759	451	342	207	228	105
ӨВ / OV	2 588	1 335	671	326	812	456	627	329	478	224
ХӨ / KHS	1 843	939	445	224	607	337	457	247	334	131
<b>Төвийн бүс/ Central region</b>	<b>6 356</b>	<b>3 560</b>	<b>1 617</b>	<b>931</b>	<b>2 228</b>	<b>1 276</b>	<b>1 448</b>	<b>833</b>	<b>1 063</b>	<b>520</b>
ГС / GS	125	77	34	19	26	20	41	28	24	10
ДА / DA	2 240	1 215	522	285	780	436	531	301	407	193
ДО / DO	999	558	264	150	357	208	210	125	168	75
ДУ / DU	550	337	133	82	165	105	144	92	108	58
ӨМ / OM	723	415	232	139	244	140	128	74	119	62
СЭ / SE	1 153	640	296	174	431	239	275	145	151	82
ТӨ / TO	566	318	136	82	225	128	119	68	86	40
<b>Зүүн бүс/ Eastern region</b>	<b>5 459</b>	<b>2 690</b>	<b>1 364</b>	<b>643</b>	<b>2 067</b>	<b>1 044</b>	<b>1 121</b>	<b>589</b>	<b>907</b>	<b>414</b>
ДД / DD	3 490	1 723	820	384	1 396	701	716	378	558	260
СҮ / SU	909	417	247	112	315	139	180	88	167	78
ХЭ / KHE	1 060	550	297	147	356	204	225	123	182	76
<b>Улаанбаатар/ Ulaanbaatar</b>	<b>11 490</b>	<b>6 090</b>	<b>3 126</b>	<b>1 699</b>	<b>3 900</b>	<b>2 135</b>	<b>2 332</b>	<b>1 226</b>	<b>2 132</b>	<b>1 030</b>
УБ / UB	11 490	6 090	3 126	1 699	3 900	2 135	2 332	1 226	2 132	1 030

\* Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

\* Monthly report of the Ministry of Labour

1.5 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ОРСОН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО\*, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 7 сард  
NUMBER OF UNEMPLOYED WHO NEWLY REGISTERED AND ACQUIRED A JOB\*, by regions, aimags and the Capital,  
as a first 7 months of the selected years

Аймаг, нийслэл Aimags and the Capital	Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд Number of newly registered unemployed			Бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүн Number of person acquired a job out of registered unemployed		
	2012 I-VII	2013 I-VII	2013 I-VII 2012 I-VII %	2012 I-VII	2013 I-VII	2013 I-VII 2012 I-VI %
<b>Дүн / Total</b>	<b>39 242</b>	<b>59 516</b>	<b>151.7</b>	<b>19 498</b>	<b>32 031</b>	<b>164.3</b>
<b>Баруун бүс/ Western region</b>	<b>5 153</b>	<b>8 859</b>	<b>171.9</b>	<b>2 777</b>	<b>4 682</b>	<b>168.6</b>
БӨ / BO	1 281	2 105	164.3	323	937	290.1
ГО / GO	635	1 284	202.2	488	451	92.4
ЗА / ZA	1 142	1 590	139.2	651	1 150	176.7
УВ / UV	725	1 452	200.3	534	590	110.5
ХО / KHO	1 370	2 428	177.2	781	1 554	199.0
<b>Хангайн бүс/ Khangai region</b>	<b>7 383</b>	<b>15 714</b>	<b>212.8</b>	<b>2 557</b>	<b>7 294</b>	<b>285.3</b>
АР / AR	591	2 507	4.2**	553	1 325	239.6
БХ / BKH	1 618	2 251	139.1	557	1 153	207.0
БУ / BU	997	1 171	117.5	265	547	206.4
ОР / OR	742	3 718	5.0**	335	1 855	5.5**
ӨВ / OV	2 555	3 893	152.4	711	1 214	170.7
ХӨ / KHS	880	2 174	247.0	136	1 200	8.8**
<b>Төвийн бүс/ Central region</b>	<b>6 144</b>	<b>8 865</b>	<b>144.3</b>	<b>3 678</b>	<b>4 861</b>	<b>132.2</b>
ГС / GS	299	254	84.9	159	152	95.6
ДА / DA	1 391	1 872	134.6	913	1 253	137.2
ДО / DO	587	1 024	174.4	493	782	158.6
ДУ / DU	658	804	122.2	296	399	134.8
ӨМ / OM	764	1 584	207.3	254	687	270.5
СЭ / SE	907	2 098	231.3	708	1 167	164.8
ТӨ / TO	1 538	1 229	79.9	855	421	49.2
<b>Зүүн бүс/ Eastern region</b>	<b>3 614</b>	<b>5 821</b>	<b>161.1</b>	<b>2 165</b>	<b>2 803</b>	<b>129.5</b>
ДД / DD	1 357	3 047	224.5	556	1 149	206.7
СҮ / SU	1 325	1 762	133.0	806	886	109.9
ХЭ / KHE	932	1 012	108.6	803	768	95.6
<b>Улаанбаатар/ Ulaanbaatar</b>	<b>16 948</b>	<b>20 257</b>	<b>119.5</b>	<b>8 321</b>	<b>12 391</b>	<b>148.9</b>
УБ / UB	16 948	20 257	119.5	8 321	12 391	148.9

\* Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

\* Monthly report of the Ministry of Labour

\*\*Дахин

\*\*Times more

1.6 АЖЛЫН ШИНЭ БАЙРАНД АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО\*, насны бүлэг, хүйс, бүс, аймаг, нийслэлээр, 2013 оны эхний 7 сард  
NUMBER OF PERSONS HAVE ACQUIRED A JOB AT THE NEW WORKPLACES\*, by age groups, sex, regions, aimags and the Capital, as a first 7 months of 2013

Аймаг, нийслэл Aimags and the Capital	Бүгд Total	Үүнээс: Насны бүлгээр Of which: By age groups										
		Эмэгтэй Female	15-24	Эмэгтэй Female	25-34	Эмэгтэй Female	35-44	Эмэгтэй Female	45-59	Эмэгтэй Female	60+	Эмэгтэй Female
<b>Дүн / Total</b>	<b>30 522</b>	<b>13 887</b>	<b>5 458</b>	<b>2 169</b>	<b>10 782</b>	<b>4 974</b>	<b>7 749</b>	<b>3 728</b>	<b>6 104</b>	<b>2 844</b>	<b>429</b>	<b>172</b>
<b>Баруун бүс/ Western region</b>	<b>4 319</b>	<b>1 910</b>	<b>683</b>	<b>275</b>	<b>1 445</b>	<b>690</b>	<b>1 241</b>	<b>575</b>	<b>894</b>	<b>354</b>	<b>56</b>	<b>16</b>
БӨ / BO	1 235	458	266	97	467	182	328	126	166	52	8	1
ГО / GO	538	263	98	33	177	95	147	78	112	55	4	2
ЗА / ZA	957	468	89	45	251	141	323	164	266	111	28	7
УВ / UV	618	310	70	32	210	121	167	87	169	69	2	1
ХО / KHO	971	411	160	68	340	151	276	120	181	67	14	5
<b>Хангайн бүс/ Khangai region</b>	<b>5 448</b>	<b>2 661</b>	<b>745</b>	<b>372</b>	<b>1 856</b>	<b>892</b>	<b>1 546</b>	<b>806</b>	<b>1 220</b>	<b>559</b>	<b>81</b>	<b>32</b>
АР / AR	749	308	131	55	248	90	200	89	154	64	16	10
БХ / BKH	621	330	108	50	215	122	183	114	112	43	3	1
БУ / BU	569	253	65	29	189	87	164	74	145	63	6	0
ОР / OR	1 027	539	129	64	367	194	252	142	256	128	23	11
ӨВ / OV	1 314	604	170	77	449	204	398	199	274	119	23	5
ХӨ / KHS	1 168	627	142	97	388	195	349	188	279	142	10	5
<b>Төвийн бүс/ Central region</b>	<b>3 591</b>	<b>1 751</b>	<b>611</b>	<b>249</b>	<b>1 304</b>	<b>627</b>	<b>907</b>	<b>478</b>	<b>722</b>	<b>376</b>	<b>47</b>	<b>21</b>
ГС / GS	168	109	16	7	48	27	50	37	50	36	4	2
ДА / DA	741	316	116	41	311	132	183	82	120	57	11	4
ДО / DO	568	266	117	47	188	94	128	59	126	63	9	3
ДУ / DU	205	103	33	15	75	44	58	23	36	19	3	2
ӨМ / OM	464	238	91	41	177	86	100	57	91	51	5	3
СЭ / SE	915	474	158	65	296	153	250	146	200	105	11	5
ТӨ / TO	530	245	80	33	209	91	138	74	99	45	4	2
<b>Зүүн бүс/ Eastern region</b>	<b>2 015</b>	<b>913</b>	<b>404</b>	<b>182</b>	<b>741</b>	<b>334</b>	<b>494</b>	<b>215</b>	<b>343</b>	<b>164</b>	<b>33</b>	<b>18</b>
ДД / DD	1 001	411	205	78	374	152	245	103	168	73	9	5
СҮ / SU	358	156	56	30	142	60	84	35	60	24	16	7
ХЭ / KHE	656	346	143	74	225	122	165	77	115	67	8	6
<b>Улаанбаатар/ Ulaanbaatar</b>	<b>15 149</b>	<b>6 652</b>	<b>3 015</b>	<b>1 091</b>	<b>5 436</b>	<b>2 431</b>	<b>3 561</b>	<b>1 654</b>	<b>2 925</b>	<b>1 391</b>	<b>212</b>	<b>85</b>
УБ / UB	15 149	6 652	3 015	1 091	5 436	2 431	3 561	1 654	2 925	1 391	212	85

\* Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

\* Monthly report of the Ministry of Labour

Бүлэг 1. Хөдөлмөр

1.7 АЖЛЫН ШИНЭ БАЙРАНД АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО\*, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар  
 NUMBER OF PERSONS HAVE ACQUIRED A JOB AT THE NEW WORKPLACES \*, by economic divisions,  
 as a first 7 months of the selected yeas

Салбар	Divisions	2012 I-VII	Эмэгтэй Female	2013 I-VII	Эрэгтэй Male	2013 I-VII 2012 I-VII %
<b>БҮГД</b>	<b>TOTAL</b>	<b>24 655</b>	<b>10 498</b>	<b>30 522</b>	<b>13 887</b>	<b>123.8</b>
<b>Үүнээс:</b>	<b>Of which:</b>					
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Agriculture, forestry, fishing & hunting	3972	1 640	2 759	1 238	69.5
Уул уурхай, олборлолт	Mining & quarrying	2386	581	1 452	417	60.9
Боловсруулах үйлдвэрлэл	Manufacturing	3519	1 679	5 349	2 892	152.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Electricity, gas, steam and air conditioning supply	453	213	197	41	43.5
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	Water supply; sewerage, waste management and remediation activities	414	203	239	67	57.7
Барилга	Construction	4826	1 402	7 030	1 940	145.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Wholesale & retail trade, repair of motor vehicles and motorcycles	3282	1 711	2 739	1 365	83.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Transportation and storage	609	127	916	228	150.4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	Accommodation and food service activities	1297	830	801	584	61.8
Мэдээлэл, холбоо	Information and communication	187	81	305	149	163.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Financial and insurance activities	187	111	459	294	245.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Real estate activities	35	12	52	23	148.6
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Professional, scientific and technical activities	49	21	64	25	130.6
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Administrative and support service activities	26	9	395	192	15.2**
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Public administration and defence; compulsory social security	618	331	1 460	758	236.2
Боловсрол	Education	620	406	950	660	153.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Human health and social work activities	237	171	590	455	248.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	Arts, entertainment and recreation	131	64	135	68	103.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Other service activities	1669	832	4 532	2 434	271.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	Activities of households as employers	121	70	89	52	73.6
Олон улсын байгууллага, суурин төлөлөгчийн үйл ажиллагаа	Activities of extraterritorial organizations and bodies	17	4	9	5	52.9

\* Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

\* Monthly report of the Ministry of Labour

\*\*Дахин

\*\*Times more

**II. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ**  
**SOCIAL INSURANCE AND WELFARE**

2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар  
REVENUE AND EXPENDITURE OF SOCIAL INSURANCE FUND, by types, as a first 7 months of the selected years

		2011 I-VII	2012 I-VII	2013 I-VII	2013 I - VII 2012 I - VII %
<b>Нийгмийн даатгалын сангийн орлого, сая төг</b>	<b>Revenue of social insurance fund, mln.tog</b>	<b>390 652.4</b>	<b>575 700.7</b>	<b>720 217.4</b>	<b>125.1</b>
Үүнээс:	Of which:				
Тэтгэврийн даатгалын сангийн	Retirement insurance fund	279 794.4	420 346.5	513 114.3	122.1
Тэтгэмжийн даатгалын сангийн	Benefit insurance fund	14 134.1	19 690.3	37 086.2	188.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	Health insurance fund	63 303.2	85 399.4	109 380.5	128.1
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	IAOD* insurance fund	20 444.6	32 088.4	42 728.9	133.2
Ажилгүйдлийн даатгалын сангийн	Unemployment insurance fund	12 976.0	18 176.1	17 907.5	98.5
<b>Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төг</b>	<b>Expenditure of social insurance fund, mln.tog</b>	<b>342 557.1</b>	<b>497 829.2</b>	<b>611 968.3</b>	<b>122.9</b>
Үүнээс:	Of which:				
Тэтгэврийн даатгалын сангийн	Retirement insurance fund	260 388.4	387 296.7	479 131.6	123.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	Benefit insurance fund	16 153.0	21 826.3	32 111.7	147.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн	Health insurance fund	48 760.8	68 500.4	72 842.0	106.3
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	IAOD* insurance fund	12 264.3	15 867.8	17 102.4	107.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн	Unemployment insurance fund	4 990.6	4 338.0	10 780.6	248.5

Тайлбар: \* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Note: \* IAOD - Industrial accident and occupational disease

2.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ,  
тэтгэврийн төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар  
NUMBER OF INSURED PERSONS FOR COMPULSORY SOCIAL INSURANCE AND PENSION ALLOCATED,  
by types of pensions, as a first 7 months of the selected years

		2011 I-VII	2012 I-VII	2013 I-VII	2013 I - VII 2012 I - VII %
<b>1. Заавал даатгуулагчдын тоо</b>	<b>Number of insured persons for compulsory insurance</b>	<b>540 509</b>	<b>613 404</b>	<b>673 555</b>	<b>109.8</b>
Үүнээс:	Of which:				
Аж ахуйн нэгж, байгууллага	Establishments & institutions	341 656	404 609	449 480	111.1
Төсөвт байгууллага*	Government budgetary organization*	198 853	208 795	224 075	107.3
<b>2. Олгосон тэтгэвэр, сая төг</b>	<b>Amount of granted pensions, mln.tog</b>	<b>254 562.8</b>	<b>378 242.9</b>	<b>468 285.0</b>	<b>123.8</b>
Үүнээс:	Of which:				
Өндөр настны	Retirement	189 341.0	274 621.0	342 398.9	124.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	Disabled pensions	31 377.2	48 200.5	57 296.3	118.9
Тэжээгчээ алдсаны	Breadwinner loss pension	16 611.9	22 894.0	26 881.0	117.4
Цэргийн	Military	17 232.7	32 527.4	41 708.8	128.2

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээ

Source: Report of the General Authority for Social Insurance

